

АМЕРИК ЯАГААД ДАХИН ТЭРГҮҮЛЭХ ЁСТОЙ ВЭ: Д.ТРАМПЫН ДАРААХ АНУ-ЫН ГАДААД БОДЛОГЫГ АВРАХ НЬ*

АНУ-ын Дэд ерөнхийлөгч асан Жозеф Байден

Ерөнхийлөгч Барак Обама бид хоёр 2017 оны 1 дүгээр сарын 17-нд албанаас бууснаас хойш АНУ-ын нэр нөлөө, алдар хүнд зүйл бүрээр буурсаар өдий хүрлээ. Ерөнхийлөгч Дональд Трамп АНУ-ын холбоотнууд, түнш орнуудыг үл ойшоож, басамжилж, бүр заримыг нь хөсөр хаясан. Өөрсдийнхөө дипломатууд, тагнуулын мэргэжилтнүүд, цэргүүдээс ч нүүрээ буруулсан билээ. Тэгэх мөртлөө атаатан дайснуудад тал өгч, үндэсний аюулгүй байдалд учирсан аюул заналыг үгүй хийх хөшүүргийг хугалж хаясан. Хойд Солонгосоос Иран хүртэл, Сириэс авахуулаад Афганистан, Венесуэл хүртэл хийж гавьсан юм алга. Харин ч утга учиргүй худалдааны дайн эхлүүлж, Америкийн найз, дайсныг ялгалгүй хамарсан энэ дайн Америкийн дундаж даваргыг нэрвэж байна. Ялангуяа энэ эрин зууны онцлог болон шинээр гарч ирж буй аюул заналын эсрэг хамтын хүчээр тэмцэх Америкийн манлайллыг үгүй хийж хаясан хүн. Хамгийн гол нь биднийг нэг ард түмэн болон нэгтгэдэг, манай үндэстний хүч чадал болсон ардчиллын үнэт зүйлсээс татгалзлаа.

Энэ зуур цаг уурын өөрчлөлт, хүн ард бөөнөөрөө цагаачлах, технологийн эмх замбараагүй хөгжил, халдварт өвчин зэрэг АНУ төдийгүй дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлууд улам хурцдаж, шийдвэрлэх хугацаа нь тулж ирлээ. Гэтэл эзэрхэг ёс, үндсэрхэг үзэл, явцуу бодол эдгээр асуудлуудыг шийдэх бидний хамтын хүчийг султгачихлаа шүү дээ. Улс төрийн намууд нь шуудайд хийсэн үхрийн эвэр шиг харгалдаж, авилга хээл хахууль ардчиллыг доош нь живүүлж, нөгөө талаас нь хэт тэгш бус байдал чангааж байгаа болохоор ард түмэнд ач тусаа өгч чадахгүй байна. Ардчилсан институтуудад итгэх итгэл буурлаа. “Нөгөөдүүл”-ээс айх айдас ихсэв. АНУ-ын ур ухаанаа шавхаж босгосон олон улсын тогтолцоо оёдол зүйдлээрээ салж байна. Трамп төдийгүй дэлхийгээр тарсан “попрогчид” зөвхөн өөрсдийнхөө хувийн ашиг сонирхлыг хангах, улс төрийн хожоо олохын тулд эрх мэдэлд дурлаж байна.

АНУ-ын дараагийн ерөнхийлөгч 2021 оны 1 дүгээр сард ийм улс орныг хүлээж авч, хагарч хэмхэрснийг нь эвлүүлж нийлүүлэх их ачаа үүрэх нь. Бидний унасан

* Англи хэлнээс орчуулсан ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Л.Бямбаханд

Орчуулагчийн тайлбар: АНУ-ын Ерөнхийлөгчийн 2020 оны сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшсэн АНУ-ын Дэд ерөнхийлөгч асан Жозе Байден нэр дэвшиж ялалт байгуулсан билээ. Толилуулан буй нийтлэл нь “Foreign affairs” сэтгүүлийн 3 болон 4 дүгээр сарын дугаарт нийтлэгдсэн бөгөөд нэр дэвшигч Ж.Байден америкийн ард түмний итгэлийг авч сонгогдвол АНУ-ын гадаад бодлогыг хэрхэн залж чиглүүлэх тухайгаа энэ нийтлэлд дэлгэрэнгүй бичсэн. Тэрээр АНУ-ын 46 дугаар ерөнхийлөгчөөр тангараг өргөх нь тодорхой болсон тул дэлхийн бодлогод тэргүүлэх үүрэгтэй энэ улсын гадаад бодлого ирэх дөрвөн жилд ямар чиг хандлагатай байхыг энэ нийтлэлээс унших боломжтой юм.

нэр хүндийг өөд нь татаж, удирдагчдаа итгэх итгэлийг сэргээж, улс орноо анд нөхөд холбоотнуудын хамт хөдөлгөж өмнө тулгарсан асуудлуудаа нэн даруй шийдэх хэрэгцээ тулгарна. Дэлхийн хоёр дайнд биднийг ялуулж, “Төмөр хөшөг”-ийг буулгасан хүч чадлаа сэргээж, эр зоригоо сэрээх цаг нэгэнт иржээ.

Фашизм, автократ үзлийг ардчилал, либерал үзэл ялж чөлөөт ертөнцийг бүтээсэн. Энэ тэмцэл өнгөрсөнд үлдсэн төдий юм биш. Бидний ирээдүйг ч тодорхойлно.

Улс орондоо ардчиллыг шинэтгэе

Давын өмнө бид өөрсдийнхөө ардчиллыг засаж, шинэ хүчээр сэлбэх хэрэгтэй. Үүний хажуугаар дэлхий дахинаа бидэнтэй холбоолон буй ардчиллын эвслийг бэхжүүлэхээ орхихгүй. АНУ-ын дэлхий нийтэд өөрчлөлт хөгжил авчирч, хамтын хүчийг хөдөлгөх чадавхи нь улсын дотоодоос эхтэй. Яг үүний тулд би боловсролын системийг шинээр тогтооно. Хүүхдийн хаана амьдардаг, ямар үндэс угсаатай нь амьдралд хүртэх боломжийг нь тодорхойлох ёсгүй. Эрүүгийн шүүхийн системийг өөрчилж тэгш бус, ялгаатай байдлыг үгүй хийж, нийтээр нь хоморголон шоронд хорих явдлыг бууруулж, хүн бүрийн дуу хоолой олон нийтэд хүрдэг байхын тулд Саналын Эрхийн тухай хуулийг сэргээж, засгийн газарт ил тод байдал, хариуцлагыг эргүүлэн авчирна.

Гэвч ардчилал зөвхөн Америкийн нийгмийн үндэс суурь төдий биш. Бас бидний хүч чадлын ундарга юм. Чухам ардчилал л дэлхийд бидний аюулгүй байдлыг хадгалах манлайллыг өөд нь нэмэгдүүлж, хүчирхэгжүүлж байдаг. Ардчилал бол манай эдийн засгийн хөгжин мандалтыг чиглүүлж өгдөг мэргэн ухаан. Өнөө бид хэн болох, дэлхий ертөнцийг хэрхэн хардаг, эргээд дэлхий биднийг яаж харахын амин зүрх нь ардчилал билээ. Энэ л бидэнд алдаа мэдгээ өөрсдөө засаж, цаг мөч өнгөрөх тусам төгс төгөлдөр өөд тэмцэн тэмүүлэх хүчийг өгдөг.

Нэгэн үндэстний хувьд бид дэлхийд АНУ ахин манлайлахад бэлэн гэдгээ батлах хэрэгтэй. Ингэхдээ хүч чадлаа жишээлэн харуулах биш, харин үлгэр жишээ үзүүлэн хүчирхэг гэдгээ батлах хэрэгтэй. Яг үүний төлөө ерөнхийлөгчийн хувьд би үнэт зүйлсээ өөрчлөн шинэчлэх шийдэмгий алхмуудыг хийх болно. Д.Трампын засаг захиргааны улсын хил дээр эцэг эхээс нь үр хүүхдийг нь булаан салгадаг харгис, утгагүй бодлогыг нэн даруй хална. Хор хөнөөл учруулсан улс төрийн орогнол олгох бодлогыг дуусгавар болгож, хилийн хоригийг цуцална. Эмзэг буурай үндэстэнд зориулан Түр зуур хамгаалах статусыг эргэн хянахыг үүрэгдэж, жилд хүлээж авах дүрвэгсдийн тоог 125,000 хэмээн тогтооно. Өөрсдийнхөө үүрэг хариуцлага, үнэт зүйлд нийцүүлэн энэ тоог яваандаа өсгөх болно. АНУ-ын цэргийн ажиллагааны ил тод байдлыг дахин сэргээж, хүнийг эрүүдэн зовооход тавьсан хоригийг ахин баталгаажуулж, үүний дотор Обама-Байдены захиргааны үед гаргасан энгийн иргэд амиа алдах явдлыг бууруулах бодлогыг бэхжүүлнэ. Бөмбөрцөг даяарх хүүхэд, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр засгийн

газрын бодлогоо өргөн хүрээнд хэрэгжүүлнэ. Түүнчлэн Цагаан ордоныг хэвлэлийн эрх чөлөөг хүндэтгэхээс эхлээд санал өгөх дагшин эрхээ батлан хамгаалах, шүүх засаглалын эрх чөлөөг ивээн тэтгэх хүртэлх ардчиллын үнэт зүйлсийн институтууд, тулгуур багануудын гол дайсан нь биш агуу хамгаалагчаар эргүүлэн томилно. Эдгээр өөрчлөлтүүд нь ердөө эхлэл, эх орондоо ардчиллын үнэт зүйлсийг амилуулах амлалтын урьдчилгаа төдий юм.

Д.Трамп шиг гэр бүлийг бутаргаж, процессыг зөрчиж, аль нэг нийгмийн бүлгийг хараалалгүйгээр АНУ-ын хууль тогтоомжийг бэхжүүлнэ. Цагаачдын нэр хүндийг хамгаалж, орогнол хүсэх хууль ёсны эрхийг нь батжуулахын зэрэгцээ хилийн дархан байдлаа хамгаална. Энд дурдсан бодлого бүрийг нарийвчлан бичсэн, цагаачдыг зүүн өмнөд хил рүү ирэхэд хүргэж буй суурь шалтгаануудыг АНУ хэрхэн анхаарч үзэх тухай заасан төлөвлөгөө нийтлэн гаргасан. Ард иргэд нь эх орноо орхин дүрвэхэд хүргэж буй шалтгаанууд болох авилга хээл хахууль, хүчирхийлэл, улс орныг хамарсан ядуурлын эсрэг тэмцэх Сальвадор, Гватемал, Гондурас зэрэг орнуудын удирдагчдын амлалтыг хэрэгжүүлэх 750 сая долларын буцалтгүй тусламжийн хөтөлбөрийг миний бие дэд ерөнхийлөгчийн хувиар хоёр намаар дэмжүүлж чадсан. Үр дүнд нь Сальвадор зэрэг орнуудад илүү амар жимэр болж, хүн амын гадагшлах урсгал нь буурч эхэлсэн билээ. Харин ерөнхийлөгч болвол миний бие энэ санаачлагын үндэс суурь дээр нэмээд 4 тэрбум ам.долларын, дөрвөн жилийн хугацаатай цогц бүсийн стратеги хэрэгжүүлнэ. Тус хөтөлбөр нь улс орнуудыг өөрсдийн нөөц баялгийг нэмэгдүүлж, хөдлөшгүй, баталгаатай, чухал шинэчлэл өөрчлөлтүүдийг хийхийг шаардах юм.

Түүнчлэн би манай ардчиллыг ялзруулж буй, хэт явцуу, хувийн, гадны ашиг сонирхолд үйлчилж буй албан тушаалаа урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчил гаргах, улсын мөнгө шамшигдуулах, хээл хахууль авах зэрэг гаж үзэгдлүүдийг арилгах арга хэмжээ авна. Үүний тулд холбооны сонгуульд хувийн мөнгө ашиглахыг бүрэн зогсоох Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт батлуулахын төлөө тэмцэж эхэлнэ. Түүнчлэн, гадны иргэд, засгийн газрууд АНУ-ын холбооны, мужийн, орон нутгийн сонгуульд нөлөөлөхөөр оролдохыг хориглохыг чангатгах, Холбооны ёс зүйн комисс хэмээх шинэ бие даасан агентлаг томилон, тус хууль ба авилгын эсрэг бусад хуулиудыг нэгдсэн хүчээр хэрэгжүүлэх тухай хууль санаачилна. Манай сонгуулийн компани ажлын санхүүгийн тогтолцооны ил тод бус байдал, их хэмжээгээр гадны мөнгө угаах явдалтай нийлээд тогтолцооны том эмгэг үүсгэжээ. Ардчиллыг уруудуулж буй энэ мэт цоорхойг бөглөх хэрэгтэй.

АНУ-ын ардчиллын үндэс суурийг бэхжүүлэх эдгээр гол арга хэмжээг авч, бусдыгаа үйл хэрэгтээ уриалж, дэлхийн ардчилсан орнуудын удирдагч нөхдөө ардчиллыг бэхжүүлж, ахин дэлхийн гол чухал асуудал болгоход хүчээ нэгтгэхийг урих болно. Өнөөдөр ардчилал 1930 оноос хойш хамгийн эмзэг үедээ ирээд байгаа. Freedom House олон улсын байгууллагаас мэдээлснээр 41 улс 1985-2005 онд “эрх чөлөөтэй” хэмээн тэмдэглэгдсээр ирсэн атал сүүлийн таван жилийн хугацаанд эрх чөлөө нь буурсаар байна.

Хонконг, Судан, Чили, Ливан улсуудын ард иргэд нийтээрээ үнэнч шударга төр засаг хүсэмжилж, даяараа авилгалыг жигшин зэвүүцэж буйг ахин санууллаа. Авилгал хэмээх чимээгүй тахал ард иргэдийн эсэргүүцлийг өдөөж, хүний зүй ёсны эрхийг бага багаар идэж, авторитар удирдагчдыг дэлхий нийтийн ардчиллыг бутаргах, хүчгүйдүүлэх зэвсгээр хангасаар. Иймд дэлхийн ардчилсан орнууд улс орныг жинхнээр нэгтгэх үнэт зүйлсийн төлөө бат зогсогч, эрх чөлөөт дэлхий ертөнцийг бодитоор манлайлагч хэмээн АНУ-д хандахад Трамп автократуудын талд орж, ардчилагчдыг дорд үзэж байх юм. Орчин цагийн Америкийн түүхэнд хамгийн ялзарсан засаг захиргааг тэргүүлэгч тэрбээр энд тэндгүй клептократуудад эрхийн бичиг тараасаар явна.

Миний бие албандаа томилогдсон эхний жилд АНУ Ардчиллын дээд хэмжээний уулзалтыг дэлхийн хэмжээнд зохион байгуулж, чөлөөт дэлхийн үндэтснүүдийн нэгдсэн санаа зорилго, урам зоригийг сэргээн бадраана. Энэ уулзалтаар дэлхийн ардчилсан орнуудыг нэгтгэж, манай ардчилсан институтуудыг бэхжүүлэн, ухарч няцаж буй үндэстнүүдтэй шударгаар нүүр тулж, хамтын хөтөлбөр дэвшүүлнэ. Обама-Байдены засаг захиргааны үед Цөмийн аюулгүй байдлын дээд хэмжээний уулзалтын үеэр амжилттай үүсгэн байгуулсан загварт үндэслэн АНУ дараах гурван чиглэлийг барьж ажиллахаа амлаж байна. Эдгээр нь авлига, хээл хахуультай тэмцэх, авторитар үзлээс хамгаалах, өөрийн улс орон бөгөөд хилийн чанадад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг сайжруулах юм. Дээд хэмжээний уулзалт дээр АНУ амласан ёсоор миний бие авилгалтай тэмцэхийг үндэсний аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхол болгон тавих ерөнхийлөгчийн бодлогын удирдамж гаргаж, олон улсад дэлхий нийтийн санхүүгийн тогтолцоог ил тод болгохоор тэмцэх ажиллагааг удирдан тэргүүлж, хууль бусаар татвараас зайлсхийгчдийн араас мөшгиж, хулгайлагдсан эд хөрөнгийг улсын мэдэлд авч, ард иргэдээсээ хулгай хийдэг удирдагчдыг нэргүй компаниудын ард нуугдах гарцгүй болгоно.

Ардчиллын дээд хэмжээний уулзалт нь ардчиллыг хамгаалах тэргүүн фронтод дэлхий даяар тэмцэж буй иргэний нийгмийн байгууллагуудыг ч оролцуулна. Дээд хэмжээний уулзалтын гишүүд технологийн компаниуд, нийгмийн сүлжээний аварга компаниудыг оролцуулсан хувийн хэвшлийнхэнийг уриалах болно. Эдгээр байгууллагууд ардчилсан нийгмийг хадгалж үлдэх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалах үүрэг хариуцлага, ашиг сонирхлоо ухамсарлах ёстой. Түүнчлэн, үг хэлэх эрх чөлөө нь технологи, нийгмийн сүлжээний компаниудад худал гүтгэлэг тараах эрхийн бичиг болох ёсгүй. Эдгээр компаниуд өөрсдийнх нь арга хэрэгслүүд, платформууд нь иргэдээ хянадаг улсуудыг хүчирхэгжүүлэх, хувийн мэдээллийг үгүйсгэх, Хятад болон бусад газруудад иргэдийг нухчин дарахыг дэмжих, үзэн ядалт, худалд хуурмагийг түгээх, хүмүүсийг хүчирхийлэлд турхирах, өөр зүй бус зүйлсийг өдөөгч байлгахгүйг анхаарах ёстой.

Дундаж давхаргад зориулсан гадаад бодлого

Хоёрдугаарт, миний засаг захиргаа америкчуудыг дэлхийн эдийн засагт амжилт олоход нь туслах дундаж давхаргад зориулсан гадаад бодлогоор хангана. Ирээдүйн төлөөх өрсөлдөөнд Хятад, өөр ямар ч улстай өрсөлдөж ялахын тулд АНУ бүтээлч чадавхиа хурцалж, дэлхий дахины ардчилсан орнуудын эдийн засгийн хүчийг нэгтгэн эдийн засгийн зүй бус байдалтай тэмцэж, тэгш бус байдлыг бууруулвал зохино.

Эдийн засгийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдал юм. Манай худалдааны бодлого хамгийн хүчирхэг зэвсэг болох дундаж давхаргаа хүчирхэгжүүлж эхлэн, энэ орны иргэн бүр өөрийн арьсны өнгө, хүйс, суугаа газар, шашин, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээлээс үл хамааран улсынхаа амжилтыг эрх тэгш хуваалцдаг болох хэрэгтэй. Үүний тулд өргөн сүлжээ, хурдны зам, төмөр зам, эрчим хүч, ухаалаг хот зэрэг дэд бүтцийн төслүүддээ, мөн боловсролд асар их хөрөнгө оруулах хэрэгтэй. Сурагч бүрт ХХI зуунд сайн ажил олоход шаардлагатай ур чадварыг эзэмшүүлж, Америк хүн бүр чанартай, боломжийн үнэтэй эрүүл мэндийн үйлчилгээ авдаг болгож, цагийн доод цалин хөлсний хэмжээг 15 ам.долларт хүргэж, АНУ-д холбооны ажлын хамт арван сая шинэ сайн ажлын байр бий болгох цэвэр эдийн засгийн хувьслыг эхлүүлэх шаардлагатай.

Би ерөнхийлөгч байх хугацаандаа судалгаа шинжилгээ, хөгжүүлэлтэд хөрөнгө оруулж, АНУ-ыг инновацийн талбарын тэргүүлэгч болгоно. Бид цэвэр эрчим хүч, квантын компьютер, хиймэл оюун ухаан, 5G, өндөр хурдны төмөр зам, хорт хавдрыг эцэс болгох тэмцэлд Хятад юм уу, бусад улсын ард үлдэх учиргүй. Дэлхийн хамгийн шилдэг судалгааны их сургуулиуд бидэнд бий. Хууль дүрмийн хүчирхэг уламжлал бидэнд бий. Хамгийн чухал нь энэ улс орныг хэзээ ч хөсөрдүүлж байгаагүй гайхамшигтай шинийг санаачлагчид, ажилчин анги бидэнд байна.

Дундаж давхаргад зориулсан гадаад бодлого нь олон улсын эдийн засгийн дүрэм журам АНУ-ын эсрэг чиглэхгүй байхын төлөө хэрэгжинэ. Яагаад гэвэл америкийн бизнес эрхлэгчид шударга талбарт тоглохоороо ялдаг. Би шударга худалдаанд итгэдэг. Дэлхийн хүн амын 95 гаруй хувь нь манай хилийн гадна амьдарч байна. Бид тэр зах зээлд хүрэхийг хүсэж байгаа. Бид Америкийн нэгдсэн улсад хамгийн шилдгийг барьж босгон, тэр хамгийн шилдгээ дэлхий дахинаа зарж борлуулах хэрэгтэй. Энэ нь америкчуудыг торгож буй худалдааны саад тотгорыг үгүй болгож, хамгаалах үзлийн эсрэг дэлхий дахины аюултай хэвгий үзлийг эсэргүүцэнэ гэсэн үг. Дэлхийн I дайны дараа нэгэн зууны өмнө чухам ийм зүйл болсон. Энэ бүхэн их хямралыг ужигруулж, дэлхийн II дайнд хүргэсэн билээ.

Толгойгоо элсэнд шургуулж нуугдаад, худалдааны хэлэлцээр хийхгүй гэвэл хамгийн буруу зүйл. Улс орнууд АНУ-тай АНУ-гүй худалдаа хийсээр л байна. Харин худалдааг зохицуулах дүрэм журмыг хэн гаргах вэ гэдэг асуулт ургана.

Ажилчид, хүрээлэн буй орчин, ил тод байдал, дундаж давхаргынханы цалин хөлсийг хэн хамгаалах вэ? Хятад улс биш, АНУ энэ үүргийг манлайлах ёстой.

Ерөнхийлөгчийн хувьд америкчууддаа хөрөнгө оруулж, дэлхий эдийн засагт амжилт олох арга хэрэгслээр хангах хүртэл шинэ худалдааны хэлэлцээр байгуулахгүй. Бас ширээний ард хөдөлмөрийн асуудал, хүрээлэн буй орчин хариуцсан удирдагчидтай утга учиртай хэлэлцээр хийж, гарын үсэг зурж буй гэрээгээ дагаж мөрдөх хүчтэй зүйл заалтууд оруулалгүйгээр ямар ч шинэ хэлцэл хийхгүй.

Хятад улс бол том сорилт билээ. Хятадын удирдагчидтай олон цагийг өнгөрүүлсний хувьд хэнтэй нүүр тулж буйгаа би ойлгоно. Хятад дэлхий дахинд хүрээгээ тэлж, өөрийн улс төрийн загварыг хөхиүлэн дэмжиж, ирээдүйн технологид хөрөнгө оруулан урт хугацааны тоглоом тоглож байна. Харин энэ зуур Трамп улсдаа хор хохиролтой, утгагүй тариф оногдуулахын тулд хамгийн ойрын холбоотнууд болох Канадаас өгсүүлээд Европын Холбооны импортыг үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн хэрэг хэмээн онилов. Эдийн засгийн хувьд хамгийн дотно түншүүдээсээ харилцаагаа тасалснаар Трамп манай орны эдийн засгийн бодит аюулын өмнөөс сөрөх чадварыг өвдөг сөхрүүлэв.

АНУ Хятадтай сөргөөцөлдөх албагүй. Хятадыг зөнгөөр нь орхивол АНУ, Америкийн компаниудын технологи, оюуны өмчийг дээрэмдсээр л байна. Төрийн өмчит компаниуддаа татаас өгч шударга бусаар давуу тал олгон, ирээдүйн технологи, аж үйлдвэрт ноёрхоход нь дэм өгсөөр байна.

Энэ сорилттой тулах хамгийн үр дүнтэй арга нь Хятадын түрэмгий зан, хүний эрхийн зөрчлийн эсрэг АНУ-ын холбоотнууд, түншүүдийн хамт нэгдсэн фронт байгуулах юм. Хэрэгтэй бол хамтын ашиг сонирхол давхцаж буй уур амьсгалын өөрчлөлт, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх, дэлхий нийтийн эрүүл мэндийн аюулгүй байдал зэрэг асуудлууд дээр Хятадтай хамтран ажиллах арга ч эрэлхийлэх болно. АНУ дангаараа дэлхийн ДНБ-ий дөрөвний нэгийг эзэлдэг. Хятад улс дэлхийн эдийн засгийн талаас илүүг үл тоомсорлох хүч хүрэхгүй. Иймээс бидэнд хүрээлэн буй орчны асуудлаас эхлээд хөдөлмөр, худалдаа, технологи, ил тод байдал хүртэлх бүх асуудлыг ном журамд нь оруулах томоохон хөшүүрэг бий болно гэсэн үг. Ингэж байж ардчиллын ашиг сонирхол, үнэт зүйлсийн тусгал болсон хэвээр үлдэх юм.

Буцаад ширээний хойморт

Ж.Байдены гадаад бодлогын гол зорилт нь АНУ-ыг эргүүлээд хойморт залах буюу холбоотнууд, түншүүдтэйгээ хамтран ажиллаж, дэлхий нийтийн аюул заналын эсрэг хамтын хүч хөдөлгөх байранд аваачих юм. Дэлхий нэгэнт өөрийгөө ч танихааргүй болжээ. 70 жилийн хугацаанд Ардчилсан болон Бүгд Найрамдах намаас сонгогдсон ерөнхийлөгчдийн удирдлага дор АНУ үндэстэн хоорондын

харилцааг залж чиглүүлэн, хамтын аюулгүй байдал, хөгжил цэцэглэлтийг бэхжүүлэх дүрэм журмыг бичих, гэрээ хэлэлцээрийг урагшлуулах, институтуудыг хөдөлгөх манлайлагчийн үүргийг Д.Трамп ерөнхийлөгч болох хүртэл гүйцэтгэж ирсэн. Хэрэв зээ бид энэ үүргээ огоорсон хэвээр байвал хоёр л зүйл тохиолдоно гэж бодоорой. Нэг бол АНУ-ын байр суурийг өөр нэг нь эзэлнэ, гэхдээ бидний ашиг сонирхол, үнэт зүйлсийг эрхэмлэхгүй. Эсвэл хэн ч энэ байрыг эзлэхгүй, эмх замбараагүй байдал үүснэ. Аль нь ч байлаа Америкт тустай юм биш ээ.

Америкийн манлайлал алдаагүй байсан гэхгүй. Бид буруу алхаж, алдаа ч гаргасан. Хүчин чадлаа бүрэн дайчлахын оронд дан ганц цэргийн сүр хүчиндээ эрдэн найдсан удаа дэндүү олон бий. Трампын хөнөөлт гадаад бодлогын зам мөр бидэнд өдөр бүр тэнцвэргүй, уялдаа холбоогүй, дипломат ажиллагааны үүргийг уландaa гишгэж, хөсөр хаясан чиг хандлагын аюулыг сануулж байна.

Би шаардлагатай бол хүч хэрэглэх байсан ч америкчуудыг хамгаалахдаа хэзээ ч тээнэгэлзэхгүй. АНУ-ын ерөнхийлөгчийн үүргүүд дотроос зайлшгүй хүлээх ёстой, эн тэргүүний үүрэг бол ерөнхий командлагчийн үүрэг. АНУ дэлхийд хамгийн хүчтэй цэрэг армитай, харин ерөнхийлөгчийн хувиар би энэ хэвээр нь байлгахыг баталж, энэ зууны аюул бэрхшээлүүдийн эсрэг цэрэг армия тоноглоход шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийнэ. Тэдгээр аюул бэрхшээлүүд сүүлийнх нь биш. Гэхдээ цэргийн хүч ашиглана гэдэг эхний биш, эцсийн арга хэмжээ байх учиртай. Зөвхөн АНУ-ын амин чухал ашиг сонирхлыг хамгаалахад, хүрэх зорилт нь тодорхой, боломжтой байхад, Америкийн иргэдэд мэдэгдэн зөвшөөрөл авсны эцэст нь ашиглах ёстой юм.

АНУ-д үгээр хэлэмгүй гарз учруулж, цус асгаруулсан үүрдийн дайнуудын өндөрлөх цаг хэдийнээ өнгөрөөд уджээ. Аль олон жилийн өмнөөс миний мэтгэж байсанчлан бид Афганистан, Ойрхи Дорнод дахь дайнуудаас цэргийн хүчнийхээ олонхийн татаж авчрах хэрэгтэй. Мөн өөрсдийн зорилгоо зөвхөн “Аль-Кайда”, “Исламын улс” (буюу ISIS) бүлэглэлийг ялах хэмээн нарийвчлан тогтоох хэрэгтэй. Йеменд болж буй Саудын Арабын толгойлсон дайнд дэмжлэг үзүүлэхээ болих ёстой. Гол анхаарлаа дэлхий дахинаа, мөн улсын дотоод дахь терроризмтай тэмцэхэд чиглүүлэх ёстой. Харин ялах боломжгүй мөргөлдөөн дунд гацсанаар илүү анхаарал тавих ёстой бусад асуудалд манлайлагчийн үүрэг гүйцэтгэх бидний хүч чадлыг сорж дуусгаж, Америкийн хүчний бусад арга хэрэгслүүдийг ахин барьж босгох бололцоо өгөхгүй байна.

Бид нэгэн зэрэг хүчтэй, ухаантай байж чадна. Америкийн цэргийн хүчийг хэдэн арван мянгаар нь маш их хэмжээгээр, хязгааргүй үргэлжлүүлэн дайчлах нэг хэрэг. Үүнийг зогсоох ёстой. Эсрэгээр нь Тусгай хүчний цөөн хэдэн зуун цэргүүд, тагнуулын хэрэгслүүдийг ашиглан хамтын дайсны эсрэг тухайн нутаг дахь түншүүддээ дэмжлэх үзүүлэх нэг өөр хэрэг. Ийм жижиг хэмжээний цэргийн ажиллагааг цэрэг зэвсэг, эдийн засаг, улс төрийн хувьд тэтгэх боломжтой бөгөөд үндэсний ашиг сонирхлыг бэхжүүлдэг.

Гэсэн хэдий ч Америкийн хүчний эн тэргүүний хэрэгсэл нь дипломат ажиллагаа байх нь зүйтэй. Обама-Байдены засаг захиргааны үед Америкийн дипломат бодлого олсон амжилтаар би бахархдаг. Уур амьсгалын тухай Парисын гэрээг хэрэгжүүлэхэд дэлхий нийтийн хүчин чармайлтыг чиглүүлэхээс эхлээд баруун Африк дахь Эболон вирусын дэгдэлтийг эцэслэхэд олон улсын арга хэмжээг удирдах, мөн Ираныг цөмийн зэвсэгтэй болохыг болиулах олон талт хэлэлцээрийг батлан хамгаалах хүртэл олон үр дүн бий. Дипломат ажиллагаа гэдэг зүгээр гар барьж зургаа авахуулах биш юм. Харин харилцаа бий болгох, хадгалах, зөрчлийн цэгийг зохицуулахын хажуугаар хамтын ашиг сонирхлоо олж тогтоохоор ажиллахыг хэлдэг. Үүнд сахилга бат, уялдаа холбоотой бодлого боловсруулах явц, туршлагатай, хүчирхэг мэргэжилтнүүдээс бүрдсэн баг шаардлагатай. Ерөнхийлөгчийн хувьд би АНУ-ын гадаад бодлогын үндсэн хэрэгсэл болох дипломат ажиллагааг өөд нь өргөнө. Би одоогийн засаг захиргааны орхигдуулсан дипломат корпусуудад дахин хөрөнгө оруулж, АНУ-ын дипломат ажиллагааг жинхэнэ мэргэжлийн хүмүүсийн гарт эргүүлэн өгнө.

Дипломат ажиллагаанд ч итгэл, нэр хүнд шаардлагатай. Гэтэл Трамп бидний итгэл, нэр хүндийг үнс болгож орхисон. Гадаад бодлого хэрэгжүүлэх явцад, ялангуяа хямралын үед аливаа үндэстний үг гэдэг хамгийн үнэтэй зүйл байдаг. Дараа дараагаар гэрээнүүдээс гарч, удаа дараалан бодлогуудаасаа ухарч, АНУ-ын үүрэг хариуцлагаас зугтан, жижиг том гэлтгүй худал ярьсаар Трамп АНУ-ын итгэл, нэр хүндийг дэлхийд сүйрүүлчихлээ.

Мөн АНУ-ыг хамгийн хэрэгтэй ардчилсан холбоотнуудаас нь хөндийрүүлсэн. НАТО-гын эвслийг эвдэн сүйтгэж, америкчуудын удирддаг хамгаалалтын бамбай мэтээр үзсэн. Манай холбоотнууд ч өөрсдийн үүргийг шударгаар гүйцэтгэх л ёстой. Ийм ч учраас би Обама-Байдены засаг захиргааны үед НАТО-гын гишүүд өөрсдийн батлан хамгаалах салбарт зарцуулах төсвийг нэмэгдүүлнэ гэсэн амлалтыг хангуулах хэлэлцээр хийж чадсанаар бахархдаг (одоо Д.Трамп өөрийнх нь гавьяа гээд байгаа). Гэвч энэ эвсэл мөнгөнөөс илүү үнэ цэнтэй, АНУ-ын өгсөн амлалт ариун гэгээн бөгөөд арилжаа наймаа бус. НАТО бол АНУ-ын үндэсний аюулгүй байдлын амин зүрхэнд буй, либерал ардчиллын идеалын хана хэрэм, үнэт зүйлсийн эвсэл юм. Тийм ч учраас албадан тулгаж, мөнгө амлаж босгосон түншлэлээс хавьгүй бат бэх, найдартай, хүчирхэг болсон юм.

Ерөнхийлөгч болвол миний бие түүхэн түншлэлээ сэргээхээс ч илүүг хийнэ. Өнөө бидэнд тулгараад буй дэлхий ертөнцөд зориулан ахин зураглахын төлөө чармайн ажиллана. Оросууд орчин цагийн түүхэн дэх хамгийн үр нөлөө бүхий улс төр-цэргийн эвсэл болох НАТО хүчирхэгжихээс эмээж буй. Оросын түрэмгийллийг сөрөхийн тулд бид эвслийн цэргийн хүчин чадлыг хурцалж, авилгын сүлжээ, буруу мэдээлэл тараах, кибер хулгай зэрэг уламжлалт бус аюулын эсрэг тэмцэх чадавхийг нь өргөтгөх хэрэгтэй. Олон улсын дэг журмыг зөрчсөнийх нь төлөө Орост бодит хариуцлага оноох ёстой. Ерөнхийлөгч Владимир Путины авторитар системийн эсрэг цөхрөлтгүй, эр зориг гарган сөрж буй Оросын иргэний нийгмийг

дэмжих ёстой.

Хамтын зорилго, үнэт зүйл бүхий бусад үндэстнүүдтэй хамтран ажиллааа гээд АНУ сул дорой болчихгүй. Харин ч илүү аюулгүй, амжилттай болно. Бид бидэнтэй хамтрах хүсэлтэй түншүүдтэйгээ дэлхий нийтийн хариуцлагыг хамтран үүрэхийн зэрэгцээ хүч чадлаа өсгөн нэмэгдүүлж, дэлхий дахинаа дүр төрхөө тэлж, үзүүлэх нөлөөгөө ихэсгэнэ. Австрали, Япон, Өмнөд Солонгостой байгуулсан холбоотны гэрээндээ ахин хөрөнгө оруулж, АНУ-ын ирээдүйг тодорхойлох бүс нутагт хамтын үнэ цэнийг бэхжүүлэхийн тулд Энэтхэгээс Индонез хүртэл түншлэлээ гүнзгийрүүлэн Хойд Америк, Европоос цаатах ардчилсан анд нөхөдтэйгөө хамтын хүчин чадлаа батжуулах хэрэгцээтэй байна. Израйлийн аюулгүй байдлыг сахин хамгаалах ган төмөр мэт бат амлалтаа сахих хэрэгтэй. Мөн Латин Америк, Африк дахь анд нөхдөө ардчиллын илүү өргөн сүлжээнд нэгтгэхийн тулд илүүг хийж, эдгээр бүс нутагт хамтран ажиллах боломжийг атган авах хэрэгтэй.

Дэлхий нийтийн итгэлийг ахин олж авахын тулд бид АНУ үгээ бодолтой хэлж, хэлснээ биелүүлдэг гэдгийг батлах болно. Манай цаг үеийг тодорхойлж буй цаг уурын өөрчлөлт, цөмийн дайны дахин шинэтгэсэн заналхийлэл, сүйтгэн хөнөөх технологи зэрэг бэрхшээлийг шийдвэрлэхэд энэ бүхэн нэн чухал.

АНУ уур амьсгалын өөрчлөлт хэмээх бидний өмнө нүүр тулаад буй оршин буйн аюул заналыг шийдвэрлэхэд дэлхийг тэргүүлэх ёстой. Үүнийг зөв хийхгүй бол өөр юу ч хамаагүй болно. 2050 он гэхэд хорт хийн ялгарал ор мөргүй болох цэвэр эдийн засгийн зам дээр АНУ-ыг гаргахын тулд би улс орондоо өргөн хүрээний, нэн яаралтай хөрөнгө оруулалт хийнэ. АНУ дэлхийн хорт хийн 15 хувийг ялгаруулдаг учир дэлхий нийтийг хөдөлгөхийн тулд эдийн засаг, ёс зүйн бүрэн эрхээ хөшүүрэг болгон ашиглана. Энэ ч мөн адил чухал. Байдены засаг захиргаа ажилдаа орсон эхний өдөр би Парисын уур амьсгалын тухай гэрээнд эргэн нэгдэж, дараа нь дэлхийн нүүрс хүчлийн хий ялгаруулагч гол улс орнуудыг хуран цуглуулсан дээд хэмжээний уулзалт зохион байгуулан, улс үндэстнүүдийг хүсэл зоригоо эрчлэхийг уриалан, хурдан, илүү үр дүнд хүрэхэд нь түлхэц үзүүлнэ. Дэлхийн тээвэр, нислэгийн салбарт хорт хийн ялгарлыг бууруулах хэрэгжихүйц амлалт гарган, амлалтаа биелүүлэх замд бусад улс орнууд АНУ-ыг эдийн засгийн хувьд таслан зогсоохгүй байх хүчтэй арга хэмжээг авахаар эрэлхийлэх болно. Үүний дотор дэлхийн нүүрс хүчлийн хийг хамгийн ихээр ялгаруулагч Хятад улсыг нүүрсний экспортыг ихээр дэмжиж, “Бүс ба зам” санаачлагаараа дамжуулан хэдэн тэрбум долларын бохир чулуужмал түлшний эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлж бусад улс орнуудад бохирдол тарьж байгааг зогсоохын төлөө тасралтгүй чармайна.

Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх, цөмийн аюулгүй байдлын тухайд АНУ байгуулсан хэлэлцээрээ орхиж байж нэр хүндтэй дуу хоолой байж чадахгүй. Иранаас эхлээд Хойд Солонгос хүртэл, Оросоос Саудын Араб хүртэл Трамп цөмийн зэвсэг дэлгэрүүлэх, цөмийн зэвсгийн шинэ хөөцөөлдөөн, бүр цөмийн зэвсэг ашиглаж мэдэх хандлага дэлгэрүүлээ. Би ерөнхийлөгч болвол шинэ эринд зэвсгийн хяналт тавих амлалтаа шинэчлэн тогтооно. Обама-Байдены засаг

захиргааны үед хийсэн Ираны цөмийн зэвсгийн түүхэн гэрээ Ираныг цөмийн зэвсэгтэй болохыг болиулсан. Гэтэл Трамп энэ гэрээг ухвар мөчдөөр хөсөр хаяж, Ираныг цөмийн хөтөлбөрөө дахин эхлүүлэхээр шахамдуулж, улам идэвхтэй болж, тэр бүс нутагт хөнөөлт дайн ахин гарах эрсдэлийг нэмэгдүүлсэн. Ойрхи Дорнодын тогтвортой байдлыг эвдэж, улс орныхоо эсэргүүцэн тэмцэгчдийг нухчин дарж, америкчуудыг шударга бусаар хорьж буй Ираны дэглэмийн талаар би эндүү бодоогүй. Бидний ашиг сонирхолд харшилж буй Ираны аюул заналыг эсэргүүцэн тэмцэх ухаалаг арга бий. Өөрсдийгөө ялагдалд хүргэх арга ч бий. Трамп сүүлийнхийг нь сонгосон. Саявтархан Ираны Кудс хүчний командлагч Касем Сулейманыг хөнөөсөн нь нэг аюулт этгээдийг зайлуулсан боловч бүс нутагт хэзээ ч дуусашгүй хүчирхийллийн мөчлөг эхлэх замыг тавьж, Ираныг цөмийн зэвсгийн гэрээний дагуу тогтоосон байсан цөмийн зэвсгийн хязгаарлалтаа хаяхад хүргэлээ. Иран улс гэрээний заалтаа эргэн хатуу дагаж мөрдөх учиртай. Хэрэв тэгвээс би ахин тус гэрээнд нэгдэж, Ираны бүс нутгийг тогтворгүй болгож буй бусад үйлдлийн эсрэг тэмцэхийн зэрэгцээ холбоотнуудтайгаа хамтран дипломат ажиллагааг өргөжүүлэн, хүчирхэгжүүлэх шинэчилсэн амлалтаа хэрэгжүүлнэ.

Хойд Солонгосын хувьд, хэлэлцээр хийгчдээ хүчитгэж, БНАСАУ-ыг цөмийн зэвсэггүй болгох хамтын зорилгоо бэхжүүлэхийн төлөө Хятад зэрэг бусад орнууд болон холбоотнуудтайгаа тогтвортой, уялдаа холбоо бүхий өргөн хүрээний ажиллагааг нэн даруй эхлүүлнэ. Түүнчлэн ОХУ, АНУ-ын хоорондох стратегийн тогтвортой байдлын зангуу болсон шинэ СТАРТ гэрээг өргөтгөхийг эрмэлзэн, үүнийг зэвсгийн хяналтын шинэ хэрэгслийн суурь болгоно. Үүнээс гадна цөмийн зэвсгийн үүргийг бууруулах амлалтаа хэрэгжүүлэх бусад алхмуудыг хийнэ. 2017 онд хэлж байсанчлан миний бие АНУ-ын цөмийн зэвсэглэлийн цорын ганц зорилго нь цөмийн довтолгооноос сэргийлэх, шаардлагатай бол няцаах билээ. Ерөнхийлөгчийн хувиар АНУ-ын цэрэг арми болон холбоотнуудтай зөвшилцөн энэ итгэл үнэмшлийг бодит болгохын төлөө ажиллах болно.

5G, хиймэл оюун ухаан зэрэг ирээдүйн технологийн тухайд бусад үндэстнүүд хэрхэн ашиглахыг нь тодорхойлох, хөгжлийг нь давамгайлахын тулд үндэсний нөөц баялгаа зориулж байна. АНУ эдгээр технологийг улам агуу ардчилал, хамтын хөгжил цэцэглэлтийг авчрахын төлөө ашиглах, улс оронд минь төдийгүй хилийн чанадад эрх чөлөөг боомилох, боломжийг хязгаарлахад ашиглуулахгүй байхын төлөө илүү ихийг хийх хэрэгтэй байна. Тухайлбал, Байдены засаг захиргаа АНУ-ын ардчилсан холбоотнуудтай хамтран хөдөө нутгийн буюу бага орлоготой зэрэг аливаа иргэдийг үл орхигдуулах, аюулгүй, хувийн хэвшлээр удирдуулсан 5G сүлжээг хөгжүүлнэ. Шинэ технологи манай эдийн засаг, нийгмийг тодорхойлохын хэрээр хөгжлийн энэ хөдөлгүүр түүхэнд гарч байсан өмнөх технологийн эргэлтүүдийн адил хууль эрх зүй, ёс зүйн хүрээнд ажиллахыг бид батлан хангаж, эцэст нь Хятад, Орос хоёр цахим эриний хуулийг бичдэг болох уралдааны төгсгөлд хүрэхээс зайлсхийх ёстой. АНУ ардчилсан нийгмүүд хөгжин цэцэглэж, нийтээрээ хөгжлийг хуваалцдаг технологийн ирээдүйг авчрахад тэргүүлэх цаг ирсэн.

Энэ бүхэн томоохон зорилгууд. Алинд нь ч АНУ-гүйгээр хүрэх боломжгүй. Бид ардчилсан нөхөдтэйгөө мөр зэрэгцэн замыг нь заан урагшилна. Бид манай нийгмийн ан цавыг гүнзгийрүүлж, ардчиллыг доройтуулж, эвсэл холбоог задлахыг горилон, үнэн зөвийг хүчээр дардаг олон улсын тогтолцоог эргүүлэн авчрахаар санаархаж буй дотоодын төдийгүй гадаад дайснуудтай тулж байна. Энэ аюул заналын эсрэг улам илүү нээлттэй байж, нөхөрлөл, хамтын ажиллагаа, эвсэл холбоотнууд болон ардчиллаа улам бэхжүүлж хариу барина.

Путин өөртөө бөгөөд өөртөө итгүүлэхээр мунхруулсан хэн бүхэнд либерал үзэл санаа гэгч “сөнөж мөхсөн” гэж хэлэхийг хүсэж байгаа. Гэхдээ хүч чадлаас нь айсандаа ингэж байгаа юм. Хүнээс хүнд цахилгаан мэт чөлөөтэй дамжих, хил дамнан түгэх, хэл соёл дамжин тархах, энгийн иргэдийг идэвхтэнүүд, зохион байгуулагчид, өөрчлөлтийн төлөөлөгчид болгон цэнэглэж чаддаг эрх чөлөөний тухай үзэл санааны хүчтэй дэлхий дээрх ямар ч цэрэг арми дүйцэхгүй.

Бид дахин нэг удаа энэ хүчээр тоноглол, дэлхийд тулгарч буй сорилт бэрхшээлтэй тулгарахаар чөлөөт ертөнцийг нэгтгэн хөдөлгөх ёстой. АНУ-д зам заан тэргүүлэх үүрэг тохоогдож байна. Ийм хүчин чадалтай өөр улс үндэстэн үгүй. Өөр ямар ч улс орон ийм үзэл санаан дээр бий болоогүй. Бид ардчилал, эрх чөлөөг тэргүүлж, нэр хүндээ эргэн сэргээж, ирээдүй өөд мохошгүй өөдрөг үзэл, нэгэн зоригоор харах учиртай.

